

2014 онд гадаад харилцаатай холбоотой хийгдэх ажлууд

- **ҮАГ-ынхувьд:**

1. Хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурсан гадаад орнуудын АДБ-уудын харилцаа, хамтын ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох
2. Харилцаа тогтоож, 2 талт хамтын ажиллагааг бэхжүүлэх боломжтой гадаадын улс орнуудын АДБ-уудын судалгааг гаргаж, хамтран ажиллах санал тавих
3. Харилцаа, хамтын ажиллагаа тогтоох болон хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын айлчлалыг гадаад орнуудын АДБ-уудад зохион байгуулах саналыг тавьж, айлчлалыг зохион байгуулах
4. Ажилтнуудыг гадаад орнуудын АДБ болон гадаадын олон улсын байгууллагуудаас зохион байгуулж буй сургалтанд хамруулах боломжийг судалж, санал тавих, хамруулах
5. ИНТОСАИ, АСОСАИ-гаас зохион байгуулах сургалт, семинаруудад ажилтнуудыг хамруулах боломжийг судлах, хамруулах
6. ҮАГ-т Санхүүгийн аудитын чадавхийг бэхжүүлэх АХБ-ны төслийг хэрэгжүүлж эхлэх
7. ДБ-ны санхүүжилтээр Гүйцэтгэлийнаудит, санхүүгийн аудит ба мэдээллийн технологийн зөвлөхүүдийг сонгон шалгаруулж, ажиллуулах

- **Орон нутгийн аудитын газруудын хувьд:**

1. Орон нутгийн аудитын газруудын харилцаа, хамтын ажиллагаа тогтоон ажиллаж буй гадаад орнуудын орон нутгийн аудитын байгууллагуудын судалгааг гарган, дүн шинжилгээ хийж, цаашид хамтран ажиллах чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
2. Цаашид харилцаа, хамтын ажиллагаа тогтоон ажиллах боломжтой гадаадын орнуудын орон нутгийн аудитын дээд байгууллагуудын судалгааг гаргаж, харилцаа тогтоон хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
3. Гадаад орнуудын АДБ-уудад зохион байгуулах Монгол Улсын Ерөнхий аудиторын айлчлалын бүрэлдэхүүнд орон нутгийн аудитын газруудын удирдлагыг хамруулах
4. Гадаад орнуудын АДБ-аас зохион байгуулах сургалтуудад орон нутгийн аудитын газруудын ажилтнуудыг хамруулах